Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага ба Толбо сумын Засаг даргын харьяа байгууллагуудад 2023 онд төлөвлөгөөт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,149.9 сая төгрөгөөр буюу 185 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	225.92	207.02	(18.90)
Авлага	189.84	162.16	(27.68)
Бараа материал	62.76	153.69	90.93
Үндсэн хөрөнгө	1,222.13	4,414.55	3,192.42
Нийт хөрөнгө	1,700.66	4,850.56	3,149.90
Өр төлбөр	0.00	8.06	8.06
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,700.66	4,842.50	3,141.84
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,700.66	4,850.56	3,149.90

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 207.02 сая төгрөг болж, оны эхнээс 18.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	225.92	207.02	(18.90)
Төгрөг	225.92	207.02	(18.90)
Төрийн сангийн харилцах	225.92	207.02	(18.90)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.0009	0.00	(0.0009)
Дүн	225.92	207.02	(18.90)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн ерөнхий орлогын данс 48.02 сая, ОНХС-гийн данс 66.8 сая, Хоршоо хөгжүүлэх сан 92.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 162.2 сая төгрөг болж, өмнөх оноос 27.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Бусад авлага	4.55	8.47	3.92
Хувь хүмүүсээс авах авлага	4.55	8.47	3.92
Зээлийн авлага	185.28	153.68	(31.6)
Хувь хүмүүст олгосон зээл	185.28	153.68	(31.6)
Дүн	189.84	162.16	(27.68)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 27.7 сая төгрөгөөр буурсан нь сумын Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага 31.6 сая төгрөгөөр буурч, бусад авлага 4.0 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Авлага данстай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 66.8 сая төгрөг болж, оны эхнээс 4.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3.98	5.30	1.32
Эм боох материал	3.98	5.30	1.32
Хангамжийн материал	58.78	61.52	2.74
Бичиг хэргийн материал	0.40	0.74	0.34
Аж ахуйн материал	32.88	10.88	(22.00)
Бусад хангамжийн материал	25.50	49.90	24.40
Дүн	62.76	66.82	4.06

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Бараа материалын данс 4.0 сая төгрөгөөр өссөн нь сумын ЗДТГ тайлант онд бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар үнэ төлбөргүй хүлээж авсан 20.0 сая төгрөгийн бараа материалыг хөрөнгийн санхүүжилтээр бүртгэж тайлагнасан алдааг залруулсан.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,487.3 сая төгрөг болж, өмнөх оноос 3,322.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	2,147.22	5,469.25	3,322.03
Барилга, байгууламж, орон сууц	958.07	968.07	10.0
Авто-тээврийн хэрэгсэл	148.63	131.64	-16.99
Машин тоног төхөөрөмж(компьютер)	524.07	568.77	44.70
Тавилга, аж ахуйн эд хогшил	20.58	20.58	0.00
Зам, гүүрийн байгууламж	39.50	39.50	0.00
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5.23	5.23	0.00
Бусад үндсэн хөрөнгө	451.13	3,735.46	3,284.33
Биет бус хөрөнгө	18.15	18.15	0.00
Программ хангамж	1.49	1.49	0.00
Бусад биет бус хөрөнгө	16.66	16.66	0.00
Дүн	2,165.37	5,487.40	(3,322.03)

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Үндсэн хөрөнгийн данс 3,322.0 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хөрөнгө болон аймаг, сумын ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс оны эхэнд үлдэгдэлгүй ба оны эцэст 8.0 сая төгрөгийн өртэй гарсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ сая төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	0.00	3.81	3.81
Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	3.81	3.81
Бусад өглөг	0.00	4.25	4.25
Байгууллагад төлөх өглөг	0.00	4.25	4.25
Дүн	0.00	8.06	8.06

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Сумын ЗДТГ ажилчидтай холбоотой 3.8 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварын өглөгтэй, Эргэлтийн эмийн сан байгууллагад төлөх 4.2 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өр төлбөр данстай холбоотой зөрчил гараагүй.

Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар ажиллагсадтай холбоотой 3.8 сая төгрөгийг өр төлбөрийг байгууллагад төлөх өглөгөөр тайлагнасан алдааг залруулсан.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,850.5 сая төгрөг болж 3,141.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгийн хэмжээгээр 3,135.8 сая төгрөгөөр болон сумын Хоршоог хөгжүүлэх сангийн өмчийн өөрчлөлтийн тайланд хийгдсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт буюу залруулгатай холбоотой байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ сая төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	492.40	492.40	0.00
Хуримтлагдсан үр дүн	777.75	3,919.59	3,141.84
Өмнөх үеийн үр дүн	4,088.80	783.80	3,305.00
Тайлант үеийн үр дүн	-3,311.04	3,135.79	-175.25
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430.50	430.50	0.00
Дүн	1,700.66	4,842.50	3,141.84

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Толбо сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан нийтдээ 1,481.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,079.6 сая төгрөгийг урсгал зардалд, 401.7 сая төгрөгийг хөрөнгийн зардалд баталжээ.

Нийт зардлын 498.6 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 524.5 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 250.6 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 100.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн, 107.6 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,258.1 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 498.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 471.3 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 250.6 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 37.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 1,257.6 төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс авахаар төлөвлөсөн санхүүжилтээс 53.1 сая төгрөгийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 5.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас орох үндсэн үйл ажиллагааны орлогыг 100.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 37.6 сая төгрөг оруулж, 62.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,257.6 сая төгрөг буюу 84.9 хувьтай байгаа нь дутуу авсан санхүүжилт болон төвлөрүүлэх шилжүүлэг, тасарсан орлоготой холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой зөрчил гараагүй.

Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт 2.4 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг оруулж тайлагнасныг залруулав.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 37.6 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Толбо сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 459.2 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 13.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 472.9 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 59 дүгээр тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг нэмж 502.7 сая төгрөгөөр баталсан бол сумын ИТХ-ын 2023 оны 68 дугаар тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг анх баталснаас 12.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 516.4 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Гүйцэтгэлээр тайлант онд 446.4 сая төгрөгийн орлого оруулж /ХХОАТ-ын буцаалтыг хассан дүнгээр/ орлогын төлөвлөгөө 70.0 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар тасарсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 19.3 сая төгрөг олгосон байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
I.Татварын орлого	509.2	424.1	-85.1	83.3%
II.Татварын бус орлого	7.3	22.3	15.0	305.4%
Нийт дүн	516.5	446.4	-70.1	86.4%

Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасрахад хүн амын орлогын албан татвар 11.9 сая, өмчийн татвар 17.8 сая, бусад татвар, төлбөр, хураамж 35.6 сая, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 19.7 сая, татварын бус орлого 1.9 сая төгрөгөөр тус тус тасарсан нь нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд:

Татварын орлогоос - Хувь хүний орлогын албан татвар нийт дүнгээрээ 51.4 сая төгрөгөөр тасарсан ба цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 39.6 сая, хөрөнгө борлуулсаны орлого 1.0 сая төгрөгөөр давж, үйл ажиллагааны орлого 49.3 сая, хөрөнгийн орлогын татвар 3.0 сая төгрөгөөр тасалж, хувь хүний орлогын албан татварын буцаалтыг 0.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Өмчийн татвар нийт дүнгээрээ 17.8 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнд: Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 0.7 сая, галт зэвсгийн татвар 1.1 сая, малын тоо, толгойн татвар 16.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Бусад татвар, төлбөр, хураамжийн орлого нийт дүнгээрээ 35.6 сая төгрөгөөр тасарсны дотор улсын тэмдэгтийн хураамж 1.1 сая, газрын төлбөр 4.2 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 22.9 сая, хог хаягдлын хураамж 7.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөр болох ан, амьтны нөөц ашигласны төлбөр 19.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Татварын бус орлого нийт дүнгээрээ 15.1 сая төгрөгөөр давж биелсэн ба торгуулийн орлого 3.9, бусад орлого 11.2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 66.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар хувь хүний орлогын албан татварын буцаалтыг хасч тооцоход 446.4 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 11.8 сая, аймгаас 498.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч нийт 956.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 975.7 сая төгрөгийн төсвийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 48.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	2023 оны		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүнгээр	хувиар
1	Сумын ИТХурал	104.11	99.20	(4.91)	95.28
2	Сумын ЗДТГазар	568.43	547.66	(20.76)	96.35
3	Орон нутгийн хөгжлийн сан	401.69	330.99	(70.70)	82.40

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Хоршоог хөгжүүлэх сан	100.00	0.20	(99.80)	0.20
	Орон нутгийн дүн	1,174.23	978.05	(196.17)	83.29
1	Толбо сумын ЕБСургууль	215.32	213.52	(1.80)	99.16
2	Толбо сумын Хүүхдийн цэцэрлэг	32.28	32.28	-	100.00
3	Толбо сумын Эрүүл Мэндийн төв	35.40	33.75	(1.65)	95.33
4	Толбо сумын Соёлын төв	24.03	-	(24.03)	-
5	Тусгай шилжүүлгийн дүн	307.04	279.55	(27.48)	91.05
	Нийт дүн	1,481.26	1,257.60	(223.66)	84.90

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд нийт 1,481.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 1,257.6 сая төгрөгийн төсвийг зарцуулж 84.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Сумын ИТХ 4.9 сая, ЗДТГ 20.7 сая, Хоршоог хөгжүүлэх сан 99.8 сая, Орон нутгийн хөгжлийн сан 70.7 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын ЗДТГ 568.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 547.7 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Энэ нь орон нутгийн төсвөөс 20.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгож, авсан санхүүжилтээс 2.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Сумын ИТХ 104.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 99.2 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зардлын гүйцэтгэл 95.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зарцуулалттай холбоотой. Хоршоог хөгжүүлэх сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зээлийн эргэн төлөлтөөс орсон орлогын гүйцэтгэлтэй холбоотой байна.

Ерөнхий боловсролын сургуулийн тогтмол зардлын төсвийн гүйцэтгэл 99 хувьтай гарсан нь орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 1.8 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчийн төсөвт хуваарилсан хөрөнгөөс 0.2 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 33.3 сая төгрөгийн нийтдээ 33.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч тээвэр шатахууны зардалд 0.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 26.7 сая төгрөгийг зарцуулж 6.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 2/59 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,048.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 20.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатанд Толбо сумын ТТЗ-ийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,120.4 сая төгрөгөөс 2 хувиар тооцоход материаллаг байдлын түвшин 22.4 сая төгрөг байна

Энэ нь төлөвлөлтийн үе шатанд төлөвлөсөн материаллаг байдлын түвшнээс 1.5 сая төгрөгөөр их ба материаллаг байдлын түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 3 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад мэдээллүүдийг бүрэн оруулсан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

- *Шилэн данстай холбоотой зөрчил илрээгүй.*

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах” албан шаардлага өгсөн.

Албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад Шилэн данстай холбоотой тайлант онд зөрчил илрээгүй, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын биелэлт хангагдсан байна.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар сумын Засаг дарга нарт “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” талаар зөвлөмж өгөгдсөн байна.

Толбо сумын ИТХ-аас нь малын татварын 2023 оны орлогын төлөвлөгөөг 45.3 сая төгрөгөөр батлуулж зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан болон сумын төрийн сан, Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 26.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 26.2 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Толбо сумын ЗДТГ	1	26.2	1	26.2						
2	Толбо сумын ИТХ										
3	Толбо сумын ОНХС										
4	Толбо сумын ХХС										
	Дүн	1	26.2	1	26.1						

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар зөрчил¹ илрээгүй.

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Толбо сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								